



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А/165

Булган сум

Гадаадад албан хэргээр ажиллуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.9 дэх заалт, Засгийн газрын 2020 оны 190 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын дипломат, албан гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймгийн Дашинчилэн сумын Засаг дарга Д.Луттөмөр, Хишиг-Өндөр сумын Засаг дарга Н.Мөнхгэрэл, Хялганат тосгоны захирагч А.Сод-Эрдэнэ нарыг 2024 оны 03 дугаар сарын 24-29-ний өдрүүдэд Бүгд Найрамдах Солонгос Улсад албан томилолтоор ажиллуулсугай.

2.Албан хэргээр ажиллах болсонтой холбогдуулан Гадаад харилцааны яамны Консулын газраас Дашинчилэн сумын Засаг дарга Д.Луттөмөр, Хишиг-Өндөр сумын Засаг дарга Н.Мөнхгэрэл, Хялганат тосгоны Захирагч А.Сод-Эрдэнэ нарт гадаад албан паспорт хүссүгэй.

3.Албан хаагчийн гадаад албан паспортын хэрэглээнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ

